

БҮС НУТГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛД БИДНИЙ ОРОЛЦОО” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургуулийн түүхт 60 жилийн ойг угтан төгсөгчдийнхөө дунд зохион байгуулж буй “Бүс нутгийн эрүүл мэндийн салбарын хөгжилд бидний оролцоо” сэдэвт эрдэм шинжилгээний хурал 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдөр Дорноговь аймгийн АУС дээр цахим, танхим хосолсон хэлбэрээр амжилттай зохион байгуулагдлаа.

Эрдэм шинжилгээний хурлын үйл ажиллагааг нээн АШУҮИС-ийн Дорноговь салбар АУС-ийн захирал, доктор М.Отгончимэг үг хэлэв.

“Бүс нутгийн эрүүл мэндийн салбарын хөгжилд бидний оролцоо” эрдэм шинжилгээний хуралд 4 зочин илтгэгч оролцов. Үүнд: АШУҮИС, АУС, Сэтгэцийн эрүүл мэндийн тэнхимийн багш, АУ-ны доктор, сэтгэцийн зөвлөх зэргийн эмч Т.Ганцэцэг “Ковидын үеийн сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал”, Дорноговь салбар АУС-ийн захирал доктор М.Отгончимэг “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн удирдлагыг судалсан нь”, Сонгдо эмнэлгийн Зүрх судас, ангиографийн эмч Ц.Намхайдорж “Европын Зүрхний Холбооноос гаргасан зүрхний дутагдлын 2021 оны зааварт орсон өөрчлөлтүүд, Зүрхний дутагдал”, Сонгдо эмнэлгийн Уушгины тэргүүлэх зэргийн эмч, АУ-ны магистр, Н.Нарьяа “Ковид 19-ын дараах хамшинжийн хяналт, оношлогоо, эмчилгээний заавар” сэдэвт илтгэл танилцуулав.

Хурлын шүүгчээр АУ-ы доктор клиникийн профессор Ц.Сарантуяа, АУ-ы доктор Н.Ариунжаргал, АУ-ны магистр Б.Хостуяа, хурлын даргаар АУ-ы доктор, клиникийн профессор Х.Удвал, АУ-ны магистр Д.Сансармаа нар ажиллав.

Эрдэм шинжилгээний хуралд сургуулийн маань үе үеийн төгсөгчид, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд идэвхтэй оролцон өөрсдийн хийсэн судалгааны бүтээлүүдээ ирүүлснийг эмхэтгэл болгон гаргалаа. Хуралд ирүүлсэн илтгэлүүдээс Дорноговь, Сүхбаатар, Дархан-Уул, Улаанбаатар хотоос оролцогчдын 17 илтгэл сонгогдон хэлэлцүүлэгдсэнээс Б.Эрдэнэцэцэг нарын “Дорноговь аймгийн 0-19 насны хүүхдүүдийн дундах хавдар өвчний тархалтыг судалсан дүн” сэдэвт илтгэл тэргүүн байр, Э.Ариунжаргал нарын “Иргэдийн цэвэр ус хадгалах савны хэрэглээний талаарх мэдлэгийг судлах нь” сэдэвт илтгэл дэд байр, эмнэлзүйн ховор тохиолдлын төрөлд Д.Бүрэнжаргал нарын “Муур уйлах хам шинж” илтгэлүүд тус тус шалгарлаа.

“Бүс нутгийн эрүүл мэндийн салбарын хөгжилд бидний оролцоо” эрдэм шинжилгээний хуралд амжилттай оролцож илтгэлээ хэлэлцүүлсэн судлаачид, шагналт байранд шалгарсан илтгэгч, судалгааны баг хамт олонд баяр хүргэе.

Бидний зохион байгуулж буй эрдмийн хурлыг дэмжин ажилласан зочин илтгэгчид, Гедеон рихтер ХХК хамт олон, судалгааны бүтээлээ ирүүлсэн үе үеийн

төгсөгчид, судлаачид болон хурал зохион байгуулах ажлын хэсгийн хамт олонд талархал дэвшүүлж ажлын амжилт хүсье.

Та бүхнийг төрөлх сургуулийнхаа 60 жилийн ойд зориулан явагдах **“THE INTERNATIONAL MEDICAL SCIENCE CONFERENCE VII”** хуралд идэвхтэй оролцохыг урьж байна.

Бие махбодийн ид хав эрүүл мэндэд байдаг
Оюун ухааны ид хав эрдэм мэдлэгт байдаг

*АШУУИС-ийн Дорноговь салбар АУС-ийн Эрдэм шинжилгээ,
мэдээлэл технологийн алба*